

МОНГОЛЫН БҮХ АРД ТҮМНИЙ СПОРТЫН XV НААДМЫН
ЗОХИОН БАЙГУУЛАХ ХОРООНЫ ХУРЛЫН ШИЙДВЭР

2022 оны 03 дугаар
сарын 30-ны өдөр

Дугаар № 01

Улаанбаатар хот

Монголын Бүх Ард Түмний Спортын XV наадмын зохион байгуулах хорооны 2022 оны 03 дугаар сарын 30-ны өдрийн хуралдаанаас ТОГТООХ нь:

1. Наадмын нэгдсэн зааврын 10.9. Пауэрлифтингийн эмэгтэй жингийн “-57 кг” гэснийг “-52 кг” гэж “Гар таталт” гэснийг “Газраас татах” гэж, 10.17. Хүндийн өргөлтийн эмэгтэй жингийн “-49 кг” гэснийг хэвээр нь үлдээх, 10.22. Пара хөнгөн атлетикийн төрлийн “F-37”, “F-38” эрэгтэй ангилал нэмж оруулсугай.


2. Наадмын бэлтгэл ажлын төлөвлөгөөг нэгдүгээр, Бүсийн тэмцээн зохион байгуулах хугацаа болон бүсийн төвүүдийг хоёрдугаар, наадмын цахим бүртгэлд хамрагдсан тамирчдын цахим гэрээний маягтыг гуравдугаар, хавсралтаар тус тус баталсугай.

3. Хурлын шийдвэрийг Биеийн тамир, спортын улсын хороонд танилцуулахыг хурлын нарийн бичгийн дарга /Б.Баярхүү/-д даалгасугай.

БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН УЛСЫН
ХОРООНЫ ДЭД ДАРГА НААДМЫН
ЗОХИОН БАЙГУУЛАХ ХОРООНЫ
ДАРГА ЦОДОНБАЯР




Наадмын Зохион байгуулах хорооны
2022 оны 03 дугаар сарын 30-ны
өдрийн хурлын тогтоолын хоёрдугаар
хавсралт



БҮСИЙН ТЭМЦЭЭН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХУГАЦАА БОЛОН БҮСИЙН ТӨВҮҮД

№	Бүс	Волейбол	Хугацаа	Сагсан бөмбөг	Хугацаа	Хөлбөмбөг	Хугацаа
1	Баруун	Баян-Өлгий аймаг Өлгий	V/13-V/15	Завхан аймаг Улиастай	V/11-V/15	Увс аймаг Улаангом	V/7-V/11
2	Хангайн	Өвөрхангай аймаг Арвайхээр	V/13-V/15	Баянхонгор аймаг Баянхонгор	V/14-V/18	Хөвсгөл аймаг Мөрөн	V/7-V/11
3	Төвийн	Өмнөговь аймаг Даланзадгад	V/13-V/15	Дундговь аймаг Мандалговь	V/17-V/20	Төв аймаг Зуунмод	V/7-V/11
4	Зүүн	Говьсүмбэр аймаг Чойр	V/13-V/15	Дорноговь аймаг Сайншанд	V/11-V/15	Сүхбаатар аймаг Баруун-Урт	V/7-V/11
5	Нийслэл	Улаанбаатар	V/11-V/20	Улаанбаатар	V/11-V/20	Төв аймаг Зуун мод	V/7-V/13

Наадмын Зохион байгуулах хорооны
2022 оны 03 дугаар сарын 30-ны
өдрийн хурлын тогтоолын
гуравдугаар хавсралт



ТАМИРЧДЫН ЦАХИМ ГЭРЭЭ

1. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

Биеийн тамир, спортын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.8, 17 дугаар зүйлийн 17.2 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2018 оны “Журам батлах тухай” 183 дугаар тогтоол, 2021 оны “Спортын наадам хойшлуулах тухай” 268 дугаар тогтоолыг тус тус үндэслэн Монголын бүх ард түмний спортын XV наадмын цахим гэрээг боловсруулав.

2. ГЭРЭЭНИЙ ЗОРИЛГО

Энэ гэрээний зорилго нь биеийн тамир, спортын салбарын мэдээллийн нэгдсэн цахим сангийн Спортын тэмцээн, наадмын системд Монголын бүх ард түмний спортын XV наадмын оролцогчдын мэдээллийг нэгдсэн зааврын дагуу бүрдүүлснээр анхан шатны тэмцээн, бүсийн тэмцээн, шигшээ тэмцээнд тус тус оролцуулах, тэмцээн, наадмын мэдээ, мэдээлэл, үр дүнг байршуулах үйл ажиллагааны хүрээнд наадмыг зохион байгуулах салбар хороо болон оролцогчийн хооронд үүсэх харилцааг зохицуулахад оршино.

3. НААДМЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХ САЛБАР ХОРООНЫ ХАРИУЦЛАГА.

- Салбарын мэдээллийн нэгдсэн цахим сангийн спортын тэмцээн, наадмын системд наадмын оролцогчийн мэдээллийг үнэн зөв оруулах
- Оролцогч тус бүртэй энэхүү гэрээг байгуулан оролцогчийн мэдээллийг хамгаалах, бусдад дамжуулахгүй байх
- Наадмын нэгдсэн зааварт туссан цахим бүртгэлийн цаг хугацааны хуваарийг мөрдүүлэн ажиллах

4. ОРОЛЦОГЧИЙН ХАРИУЦЛАГА.

- Наадмын зааврын дагуу оролцогч байгууллагын нэрийн өмнөөс спортын нэг төрлийг сонгох, наадамд оролцох
- Өөрийн мэдээллийг үнэн зөвөөр мэдүүлэх
- Тамирчны ёс зүйн дүрэм, зохион байгуулах хорооны ажилтны тавьсан шаардлага болон гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх
- Шударга өрсөлдөөнийг эрхэмлэн допинг болон хориотой бодис хэрэглэхгүй байх
- Салбарын мэдээллийн нэгдсэн цахим сангийн Спортын тэмцээн, наадмын системд өөрийн мэдээллийг байршуулахыг зөвшөөрөх

..... аймаг/дүүргийн
МБАТС-ын XV Наадмыг зохион
байгуулах салбар хорооны
бүртгэлийн ажилтан

..... аймаг/дүүргийн
МБАТС-ын XV Наадамд оролцогч
тамирчин/дасгалжуулагч (доогуур
зурах)

..... /...../

..... /...../

2022 оны сарын өдөр

2022 оны сарын өдөр